

**АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ,  
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

2018.12.20

д/д	Хэрэгжүүлэх зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	Ажлын байранд сургалт зохион байгуулах	<p>Архив, албан хөтлөлтийн чиглэлээр сургалт зохион байгуулах</p> <p>Байгууллагын архив, бичиг хэрэг хариуцсан албан хаагчийг сургалтад хамруулах</p> <p>Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах, дүн мэдээг зөв боловсруулахад дадлага олгох</p>	<p>Албан хаагчдад баримт бичгийн стандартыг хангуулах хүрээнд "Архив, албан хөтлөлтийн стандарт" сэдэвт сургалтыг 2018 оны 06 дугаар сарын 26-нд зохион байгуулж нийт албан хаагчдад хурлын тэмдэглэлийг хөтлөх зааварчилгаа, баримт бичиг боловсруулах стандартын хэмжээ гэх мэт өдөр тутам шаардагдах стандартыг нэгтгэн гарын авлага бэлтгэн тарааж ажилласан.</p> <p>2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан "Нийслэл дүүргийн тэргүүний Архивчдын анхдугаар зөвлөгөөн"-д байгууллагын дотоод болон шуурхай ажил хариуцсан мэргэжилтнийг чиг үүргийн дагуу оролцуулсан.</p> <p>Хэмжилтийн оператор, техникч 2 ажилтанд хаягдал утааны хэмжилтийн ур чадварыг олгох, хэмжилтийн дүн мэдээг боловсруулах дадлагыг эзэмшүүлэх сургалтыг ажлын талбарт нь шууд зааж сургах ажлыг 2018 оны халаалтын улиралд 16 удаа зохион байгуулсан.</p>
2	Эрдмийн ажил, сорил туршилт хийх, судалгаа шинжилгээ явуулах талаар эрдэмтдийн мэргэжлийн зөвлөл, багш, удирдагчдыг урьж, сургалт, семинар хийлгэх, ярилцлага, зөвлөгөө авах, элсэлт зохион байгуулах зэргээр дэмжлэг туслалцаа үзүүлэх	Байгууллагын чиг үүргийн хүрээнд тулгамдсан асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг семинар зохион байгуулах	Монгол Улсын сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлын хүрээнд сургалт зохион байгуулан ажиллаж тус шалгалтанд төрийн жинхэнэ 12 албан хаагчийг


			хамруулсан. Гадаадад албан томилолттой байсан 2 албан хаагч тус шалгалтанд оролцоогүй болно.
		Хэмжилт, туршилтын ажлын явцыг олон нийтэд сурталчлан таницуулах	Сайжруулсан түлшнээс агаарын чанарт хэрхэн нөлөөлж, түүхий нүүрстэй харьцуулах орчны хэмжилтийг Хан-Уул дүүргийн Морингийн давааны 572 айлын дунд 2018 оны 12 дугаар сарын 15-наас 12 дугаар сарын 25-ыг дуустал 10 хоногийн хугацаанд тасралтгүй хэмжилтийг хийж байгаа бөгөөд энэхүү хэмжилтийн талаар МҮОНРТ, Монгол Эч Ди, Ийгл ТВ-үүдээр сурталчилан ажилласан.
3	Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн	Гадаад улсад зохион байгуулагдах сургалт семинарт албан хаагчдыг оролцуулах	БНХАУ-ын Гансугийн байгалийн эрчим хүчний судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан "Хөгжиж буй орнуудын нар салхины сэргээгдэх эрчим хүчний сургалтад 1 албан хаагч, Тайвань Улсад зохион байгуулсан "Агаарын бохирдлын менежментийн бодлого" сэдэвт санал солилцох семинарт 1 албан хаагч, Хятад улсын Гансу аймгийн Ланжоу хотод "Нүүрс, сайжруулсан түлш, зуухын технологи сэдэвт сургалтад 4 албан хаагч, Япон улсын Токио хотод зохион байгуулагдсан "Агаарын бохирдлын менежментийн чадавхыг бэхжүүлэх" сургалтад 1 албан хаагч, Япон улсад "Цэвэр хөгжлийн механизм" сэдэвт сургалтад 2 албан хаагч, Хятад улсын Бээжин хотод "Бээжин, Тяньжин, Хэбэй бүс дэх агаарын бохирдлыг сайжруулах сэдэвт семинарт 1 албан хаагч, Малайз улсад Азийн хотуудын агаарын чанарын бүс нутгийн зөвлөлдөх уулзалтад 1 албан хаагч, Хятад улсад "Нүүрстөрөгчийн бага ялгаралтай хотын хөгжил" сэдэвт форумд 2 албан хаагч, давхардсан тоогоор нийт 13 албан хаагч гадаадын сургалтанд хамрагдсан.
4	Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллах нөхцөл, нийгмийн	Албан хаагчдад зэрэг дэв, удаан жилийн нэмэгдэл олгуулах	Монгол Улсын Их хурлын 1995 оны 73 дугаар тогтоол, 2000 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай журам"-ын

		тогтоолоор "Төрийн захиргааны албан хаагчид төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын дагуу болзол, хугацаа хангасан 4 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг Газрын даргын тушаалаар олгосон. /Мэргэжилтэн Ц.Баасанхүү, Н.Насанжаргал, Л.Нармандах/
	Бараа, материалын болон бусад хэлбэрийн тусламж үзүүлэх	Байгууллагын 2 албан хаагчид Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 340,000 төгрөгийн тусламж, гэр хороололд амьдардаг 3 албан хаагчид 444,900 төгрөгийн түлшний хөнгөлөлтийг Газрын даргын тушаалаар олгосон.
	Ажлын үр дүнгээс шалтгаалан мөнгөн урамшуулал олгох	Газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар байгууллагын албан хаагчдын "Үр дүнгийн гэрээ"-г дүгнэж ажиллагсдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж шагнаж урамшуулах ажил зохион байгуулсан. Байгууллагын 2018 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн "А" буюу "Маш сайн" үнэлгээгээр 2 албан хаагч, "В" буюу "Сайн" үнэлгээгээр 7 албан хаагч дүгнэгдсэн. Мөн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа 3 албан хаагч, 2018 оны IY дүгээр улиралд шинээр ажилд орсон 3 төрийн жинхэнэ албан хаагчийн хийсэн ажлын тайланг сонсож үнэлэлт дүгнэлт өгсөн. Газрын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр "А" буюу "Маш сайн", "В" буюу "Сайн" үнэлгээгээр дүгнэгдсэн болон хөдөлмөрийн гэрээний үүргээ хангалттай биелүүлсэн 12 албан хаагчид Газрын даргын тушаалаар нийт 6562276 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. Мөн байгууллагын "Оны шилдэг ажилтан"-ыг шалгаруулж нэг сарын үндсэн цалин буюу 678611 төгрөгийн урамшуулал олгосон.
Шинээр гэр бүл болох, хүүхэд төрүүлэх, төрийн одон медалиар шагнуулах зэрэг албан хаагчдад баярт үйл явдал тохиоход нь	Шинээр гэр бүл болсон, ам бүл нэмсэн албан хаагчдад мөнгөн тусламж болон бэлэг дурсгалын зүйл гардуулах	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шинэ ам бүл нэмсэн 1 албан хаагчийн ар гэрт 200,00 төгрөгийн мөнгөн тусламж олгосон.


	байгууллагаас эд хөрөнгийн болон мөнгөн тусламж үзүүлэх асуудлыг газрын дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын нэрэмжит шагнал, салбарын яамны шагналд болзол хангасан албан хаагчдыг тодорхойлж байх	2018 онд хариуцсан ажилдаа амжилт гаргасан нийт 7 албан хаагчийг салбарын болон яам, агентлаг, Нийслэлийн Засаг дарга, НИТХ-ын нэрэмжит шагналд тодорхойлон шагнуулсан. Үүнд: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны "Жуух бичиг"-ээр мэргэжилтэн Д.Санчирбаяр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хүндэт өргөмжлөл"-өөр мэргэжилтэн М.Отгонбаяр, Нийслэлийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр мэргэжилтэн Н.Нармандах, О.Алтангэрэл, Ц.Баасанхүү, Нийслэлийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн газрын "Нийслэлийн шилдэг залуу" хүндэт тэмдэгээр Н.Насанжаргал, Ц.Баасанхүү нар шагнагдсан.
5	НЗДТГ-ын эмчээс эрүүл мэндийн тусламж зөвлөгөө, үйлчилгээ авах, эмийн ба эмийн бус эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.	Албан хаагчдыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгийн үзлэг оношилгоонд хамруулах	Байгууллагын албан хаагчдыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон бусад байгууллагын дэмжлэгээр халдварт болон халдварт бус эрт илрүүлгийн болон урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулахаар судлаж байна.
		Ажлын байран дээр сүү, цагаан идээгээр хангах	Томуу, томуу тест өвчний халдвар идвэхиждэг хүйтний улиралд биеийн эсэргүүцэл, дархлаажуулалтыг сайжруулах зорилгоор ажлын өдрүүдэд ажлын байранд биеийн дасгал хөдөлгөөнийг хийлгэх ажлыг тогтмолжуулж, ажлын 1 өдөр ажлын байранд албан хаагчдад халуун аарц өгөх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
6	Эх орны байгалийн үзэсгэлэнт газруудаар болон бусад улсад жилд 1-ээс доошгүй удаа аялал зохион байгуулах	Дотоод болон гадаадын аялал, зугаалгад хамт олныг хамруулах	Монгол Улсын "Нийслэлийн өдөр"-ийг тохиолдуулан байгууллагын нийт албан хаагчид "Богд уулын дархан цаазат газар"-ын ноён оргил, байгалийн үзэсгэлэнт газар болох Цэцээ-Гүний оройд гарах аялалыг зохион байгуулсан.
7	Албан хаагчдын орон сууцны судалгааг гаргаж, орон байр худалдан авах бусад байдлаар нөхлөө сайжруулахад нь холбогдох	Орон байрны нөхцөл сайжруулах хүсэлтэй албан хаагчдыг бага хүүтэй зээлд хамруулах	Байгууллагын албан хаагчдын орон сууцны хэрэгцээ, судалгааг гаргасан. 1 албан хаагч орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.

хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын зүгээс дэмжлэг, туслалцаа үзүүлэх		
--	--	--

ТАНИЛЦСАН: ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 /Ж.АМАРМАА/

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

 /Б.МӨНХСАЙХАН/